



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/55

Хархорин сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийг сайжруулах, цахим систем нэвтрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай" а/168 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийг сайжруулах, удирдлага зохицуулалтын цахим систем нэвтрүүлэх ажлын бэлтгэлийг хангах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Х.Лхагвадулам (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Ц.Мягмарсүрэн (Төсвийн ерөнхий нягтлан бодогч)

А.Норпил (Газрын даамал)

О.Гангаацэрэн (Нягтлан бодогч)

А.Цэрэнчимэд (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Н.Отгонбаяр (Нярав)

Б.Должин (Угтах үйлчилгээний ажилтан)

Багийн Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга: С.Баасансүрэн (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

2.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийг сайжруулах, удирдлага зохицуулалтын цахим систем нэвтрүүлэх ажлын бэлтгэлийг хангах, төлөвлөсөн ажлыг хугацаанд нь багтаан зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсэг (Х.Лхагвадулам)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  БАТ-ЭРДЭНЭ

